



ЕСӨН ШИЖИР
ИНВЕСТ БАНК БҮС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЖУРАМ

2025 оны 12 сар

“Есөн Шижир Инвест ББСБ” ХХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2012 оны 12-р
сарын 16-ний өдрийн 12 тоот тогтоолын хавсралт 1



Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Есөн шижир инвест ББСБ” ХХК /цаашид “ББСБ” гэх/-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, саналаа өгөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмаар зохицуулаагүй ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, үйл ажиллагаанд Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс, Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон ББСБ-ын дүрэм, бусад журмуудыг мөрдөж ажиллана.

Хоёр. Хувьцаа эзэмшигчид

- 2.1. ББСБ-ын хувьцаа эзэмшигчид дүрмийн санд оруулсан хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, санхүүгийн хариуцлага хүлээж алдагдлыг нөхнө.
- 2.2. Хувьцаа эзэмшигчид нь дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 2.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой тэнцүү санал өгөх,
- 2.2.2. Хувьцаа эзэмшигч хуралд өөрийн биеэр оролцож чадахгүй болсон тохиолдолд Монгол Улсын Иргэний хуулийн дагуу итгэмжлэлээр төлөөлөгчөө оролцуулах, ингэхдээ итгэмжлэгдсэн төлөөлөгчийнхөө талаар хурал эхлэхээс 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 2.2.3. Эзэмшиж буй хөрөнгө буюу хувьцааныхаа хэмжээгээр хувь тэнцүүлэн өөрт ногдох хэсгийг авах;
- 2.2.4. ББСБ-ын дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, санхүү төлбөрийн чадвартай холбоотой бүх төрлийн санхүүгийн тайлан мэдээтэй танилцах;

- 2.2.5. ББСБ-аас шинээр хувьцаа, тэдгээрт хөрвөх үнэт цаас гаргах тохиолдолд өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлсэн хэмжээгээр тэргүүн ээлжинд худалдан авах;
- 2.2.6. ББСБ-ын өөрчлөн байгуулалттай холбогдуулан хувьцааг хөрвүүлэх тохиолдолд шинээр байгуулагдах компанийн хувьцааг өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлсэн тоо хэмжээгээр хөрвүүлэн эзэмших;
- 2.2.7. ББСБ-ын ашиг орлогыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн үр дүнтэй ашиглалтыг сайжруулах талаар санал, шүүмжлэл гаргах;
- 2.2.8. Компанийн хувьцаа эзэмшигч нь дангаараа, эсхүл бусад хувьцаа эзэмшигчидтэй хамтран компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тохиолдолд компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 2.2.9. Компани болон түүний энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанид учирсан хохирлыг компанийн эрх бүхий этгээдээр нөхөн төлүүлэхээр компанийн тухай хуульд заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 2.2.10. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг төлөөлөн удирдах зөвлөлд гаргах эрхтэй.
- 2.2.11. Хувьцаа эзэмшигчид олгох зээлийн хүү, зээлийн бусад нөхцөл нь ердийн нөхцлөөс хөнгөлөлттэй байж болохгүй бөгөөд ББСБ-ын дүрмийн санд оруулсан хөрөнгийг барьцаалж аливаа зээл авах эрхгүй. ББСБ-ын хувьцаа эзэмшигчийн өөрийн компаниас авсан зээлийн төлөгдөх хугацаа 6 сараас дээш хугацаагаар хэтэрсэн тохиолдолд ББСБ-ыг удирдах үйл ажиллагаанд оролцохгүй;
- 2.2.12. Бусад хувьцаа эзэмшигчдийн худалдах хувьцаа, тэдгээрт хөрвөх үнэт цаасыг эзэмшиж байгаа хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжинд худалдан авах;
- 2.2.13. ББСБ-ын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулга хийх, их хэмжээний үнийн дүнтэй хэлцэл буюу ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, ББСБ-ын зохион байгуулалттыг өөрчлөх зэрэг асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн талаар эсрэг саналтай байсан, эсхүл саналаа өгөөгүй хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компанийн тухай хуулийн дагуу шаардах;
- 2.2.14. Гаргасан нийт хувьцааны **10** буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ББСБ-ын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;

- 2.2.15. Энгийн хувьцаа эзэмшигчийн нэр хаяг, эзэмшиж буй хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй. Шаардлагыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор багтаан төлөөлөн удирдах зөвлөл мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй;
- 2.2.16. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 20 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах эрхтэй.
- 2.3.ББСБ-ын гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг хяналтын багц гэнэ.

Гурав. Хурал хуралдуулах шийдвэр гаргах

- 3.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь компанийн ээлжит хурлыг **санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор** зарлан хуралдуулна. Энэ хугацаанд хуралдаагүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлан хувьцаа эзэмшигчдийн хурлын зарлан хуралдуулна.
- 3.2.Компанийн тухай хуульд заасан хурал зарлах эрх бүхий этгээд шаардлагатай тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.
- 3.3.**Хурал хуралдуулах шийдвэрт дараах зүйлсийг тусгана.**
- 3.3.1. Хурал хуралдуулах газар, өдөр, цаг
- 3.3.2. Хурал зохион байгуулах хэлбэр
- 3.3.3. Хурлаар хэлэлцэх асуудал
- 3.3.4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам
- 3.3.5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт
- 3.3.6. Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга
- 3.3.7. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр
- 3.3.8. Хурлын дарга
- 3.3.9. Тооллогын комиссын дарга, гишүүд
- 3.4.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 3.5.Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад “бусад” гэсэн хэсэг байх шаардлагатай бол энэ нь зөвхөн Компанийн тухай хуульд заасан асуудал байна.
- 3.6. **Хурал хуралдуулах мэдэгдэлд дараах баримт, материалыг хавсаргана. Үүнд:**
- 3.6.1. хурал хуралдуулах тухай шийдвэр;

- 3.6.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар;
- 3.6.3. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа;
- 3.6.4. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд тусгагдсан хуралд оролцсон гишүүд, хурлаар хэлэлцсэн асуудал, санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн, гаргасан шийдвэр зэргийн баримт материал;
- 3.7.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлагч санал шаардлага гаргаж хурал зарлаж байгаа бол хурлын мэдэгдэлд дараах баримт, материалыг хавсаргана. Үүнд:**
- 3.7.1. ТУЗ-д санал шаардлага хүргүүлснийг нотлох баримт /албан бичгийн хуулбар, түүнийг хүлээн авсан ТУЗ-ийн даргын гарын үсэг, санал шаардлагад өгсөн ТУЗ-ийн хариу, хариу өгөөгүй тохиолдолд хурал зарлаж буй хувьцаа эзэмшигчийн тайлбар/;
- 3.7.2. Саналын эрх бүхий хувьцааны **10** ба түүнээс дээш хувийг эзэмшиж буйг батлах хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн тодорхойлолт.
- 3.8.Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоно.
- 3.9.Компанийн тухай хуульд заасантай нийцүүлж ТУЗ бүртгэх өдрөөс хойш хувьцаа худалдан авсан этгээдийг хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

Дөрөв. Хурлын зар хүргэх

- 4.1.Компани хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гарснаас хойш **5** хоногийн дотор хурлын зарыг нийтэд мэдээлнэ.
- 4.2.Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас **30** болон түүнээс багагүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан **хоёр** ба түүнээс дээш удаа хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлнэ.
- 4.3.Энэ журмын **3.3**-т заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш **15** хоногийн дараа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.

4.4.Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг энэ журмын 3.3-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.

4.5. Хурлын зард дараах мэдээллийг заавал тусгана:

- 4.5.1 компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар;
- 4.5.2 хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
- 4.5.3 хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
- 4.5.4 хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг;
- 4.5.5 хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;
- 4.5.6 компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 5.1.ББСБ-ын эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит, ээлжит бус хэлбэрээр явагдана.
- 5.2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлыг компанийн тухай хуулийн дагуу хуралдуулна. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 5.3.Нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.
- 5.4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах үед хувьцаа эзэмшигчид дараах баримт бичигтэй танилцах бололцоог олгоно:
 - 5.4.1. компанийн санхүүгийн жилийн тайлан;
 - 5.4.2. санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
 - 5.4.3. тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт;
 - 5.4.4. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;
 - 5.4.5. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;

- 5.4.6. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал;
- 5.4.7. Хувьцаат компанийн хувьд бизнесийн үйл ажиллагааны тайлан;
- 5.4.8. Хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл.

5.1. Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

- 5.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний **50**-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
- 5.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны **10** буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
- 5.1.3. Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн **30** хувиас хэтэрсэн;
- 5.1.4. Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- 5.1.5. Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэр гаргасан;
- 5.1.6. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- 5.1.7. Компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

5.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах байдлаар асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Үүнд:

- 5.2.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах,
- 5.2.2. Өөрийн хөрөнгийн /зарласан хувьцаа/ бүтэц, хэмжээг тогтоох, өөрчлөх,
- 5.2.3. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- 5.2.4. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- 5.2.5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай, ногдол ашгийн хэмжээг тогтоох, хуваарилах,
- 5.2.6. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
- 5.2.7. Аудитын байгууллагаар шалгуулж дүгнэлт гаргуулсан санхүүгийн тайлан, тэнцлийг хэлэлцэж батлах,
- 5.2.8. Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг үндэслэн үнэт цаас гаргахад зөвшөөрөл олгох,
- 5.2.9. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэж батлах,
- 5.2.10. Энгийн болон давуу эрхийн хувьцаа, тэдгээрт хөрвөх үнэт цаас гаргах,

- 5.2.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, хугацаанаас өмнө гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох,
- 5.2.12. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
- 5.2.13. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 5.2.14. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 5.2.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- 5.3. Хувьцаа эзэмшгчдийн хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар хэлэлцэж болно.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс

- 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргалагч хурлын тооллогын комиссыг томилно.
- 6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.
- 6.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс дараах үүрэг хүлээнэ:**
- 6.3.1. хурлын ирц /кворум/-ыг тогтоож, хурлын даргад мэдээлэх;
- 6.3.2. тухайн хурлын хэлэлцэх асуудал тус бүрээр оролцогч бүрийн саналын эрхийн тоо, төрлийг тогтоох;
- 6.3.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх;
- 6.3.4. санал өгөх журмыг тайлбарлах;
- 6.3.5. санал өгөх журам болон хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
- 6.3.6. санал хураалтыг саналын хуудсаар явуулж байгаа тохиолдолд уг саналын хуудсыг тоолж, хүлээн авах;
- 6.3.7. санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэл хөтлөх;
- 6.3.8. санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, хуралд танилцуулах;
- 6.3.9. саналын хуудсыг компанийн архивт хадгалуулахаар шилжүүлэх.
- 6.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна.

Долоо. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

7.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд уг тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга хариуцна.

7.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг агуулсан байна:

7.2.1. хурал болсон газар, он, сар, өдөр, цаг;

7.2.2. хурлын даргын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

7.2.3. хурлаар хэлэлцсэн асуудал;

7.2.4. хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;

7.2.5. саналын хуудас хэрэглэсэн бол уг саналын хуудасны загвар;

7.2.6. хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, гаргасан шийдвэрийн бүрэн томъёолол.

7.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

7.4.Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүн, гаргасан шийдвэрийг тухайн хурал дээр зарлан мэдэгдэнэ.

7.5.Компани болон хувьцаа эзэмшигч нь шаардлагатай гэж үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийн үнэн зөвийн баталгаа болгож тодорхой техник хэрэгсэл ашиглан бичлэг хийж болно.

7.6.Хувьцаа эзэмшигч бичлэг хийсэн тохиолдолд түүний хувийг компани шаардан авч хадгална.

Найм. Бүртгэл, хяналт, санхүүгийн тайлан

8.1.Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жилд нэгээс доошгүй удаа аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хэвлүүлнэ.

8.2.Санхүүгийн тайлан нь тайлан тэнцэл, орлого, үр дүнгийн тайлан, хуримтлагдсан ашгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нэмэлт тайлбар, тодруулгаас бүрдэнэ.

8.3.ББСБ-ын санхүүгийн ажил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

9. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт /баримтын шалгалт/-ын дүнг үндэслэн компанийн аудитор нь дараах мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана:

9.1.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;

- 9.1.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлох;
- 9.1.3. шалгалтын хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, уг хэлцлийг энэ хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай тодорхойлолт;
- 9.1.4. хувьцаат компанийн хувьд үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад мэдээлэл;
- 9.1.5. компанийн дүрэм болон аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээгээр тодорхойлсон бусад мэдээлэл.
- 9.1.6. Аудитын байгууллага нь өөрийн хийсэн аудитын дүгнэлтээс үүссэн хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

Ес. Ногдол ашиг хуваарилалт

- 9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хувьцаа тус бүрт хуваарилан олгох ногдол ашгийн хэмжээг тогтооно. Ногдол ашиг хуваарилан олгох, эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 9.2. **Дор дурьдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй:**
- 9.2.1. Хуваарилагдах ашиг үлдээгүй;
- 9.2.2. Компанийн үйл ажиллагааг цаашид өргөтгөх, хэвийн явуулах үүднээс ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн;
- 9.2.3. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон ББСБ-ын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санхүүг бүрэн бүрдүүлээгүй;
- 9.2.4. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон ББСБ-ын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангасан ч ногдол ашгийг хуваарилсаны дараа эдгээр үзүүлэлт хангагдахгүй бол;

Арав. Арга хэмжээ авах, хариуцлага

- 10.1. Дотоодод мөрдөгдөх бусад журам, заавар, стандартыг энэхүү журамд нийцүүлэн батална. Ажилтан нь энэ журмын хэрэгжилтийн талаар санал, гомдлоо бичгээр гаргаж болно.
- 10.2. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлэх ажлыг хариуцна.
- 10.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хөдөлмөрийн хууль, компанийн хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

10.4.Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч дараах үндэслэлээр шүүхэд гомдол гаргаж болно:

10.4.1. энэ хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаагүй;

10.4.2. хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах шийдвэр гарснаас хойш хуралдах өдөр, газрыг өөрчилсөн;

10.4.3. хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцсэн.

Арван нэг. Бусад зүйлс

11.1.Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба журмыг баталсан өдрөөс эхлэн нийт хувьцаа эзэмшигчид дагаж мөрдөнө.

11.2.Энэхүү журмыг хувьцаа эзэмшигчдийн өмнөөс ТУЗ хяналт тавьж, мөрдүүлнэ.

_____оОо_____